Сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд уурхайн орчимд тарьсан модны арчилгаа усалгааг тогтсон хуваарь гаргаж услах ажлыг хийсэн. Усалгааг хувиарын дагуу тогтмол кемпийн модыг 3 хоногтоо нэг удаа, уурхайн үүдний хэсэгт тарьсан модыг 2 хоногт 1 удаа, биологийн нөхөн сэргээлтийн талбай болон модыг өдөр бүр услах ажлыг хийж хэргэжүүлсэн. Мөн уурхайн үүдний хэсэгт 200 гаруй сухай, хайлаас модыг хашаа, усны танк, усалгааны системийн хамт хийлээ. Өнгөрсөн жил уурхайн хотхоны мод хашаагүй байсанаас мал их орж идсэн модны ургалтанд сөрөг нөлөө үзүүлсэн ихэнх мод үхжих байдалтай болсон байна. Кемпийн баруун талд тарьсан модны хашаа барьж тогтмол усалсанаас ургалтад сайнаар нөлөөлсөн. 2023 оны 09 дүгээр сарын байдлаар **19,160** м³ усыг ногоон байгууламжийн усалгаанд зарцуулсан байна. Усалгааг 05 дугаар сарын эхнээс эхэлж хийсэн бөгөөд ногоон байгууламжийн усалгаанд намираа болон дуслын усалгааны аргыг хэрэглэснээс ус зарцуулалт маш багассан юм.



Зураг 15. Уурхайн хотхоны орчинг сайжруулах зорилгоор намираа усалгаа ашиглаж зүлэгжүүлэлтын ажлыг хийв.



Зураг 16. Уурхайн орчинд тарьсан ногоон байгууламжийн усалгаа хийгдэж буй байдал



Зураг 17. 2022 онд хийсэн биологийн нөхөн сэргээлтийн усалгаа арчилгааг 2 дах жилдээ хийжэ ажилласан



5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 9. Нөхөн сэргээлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хураангуй

№	Нөхөн сэргээлтийн төрөл	Нөхөн сэргээсэн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Биелэлт
1	Шимт хөрс хуулах	Хөрсний үржил шимт хөрсийг үеийг хуулах	га	77.74	2023 оны 09-р сарын 30-ны байдлаар эвдрэлд орсон нийт 77.74 га талбайгаас үржил шимт хөрс хуулах, хадгалах ажил хийгдсэн. Шимт хөрсийг нийт 4 талбайд хадгалаж байна. 2023 онд шимт хөрсний овоолгыг хаягжуулалт хийж шимт хөрсний хуулалт хадгалалт дээр MNS стандартыг баримтлан ажиллаж байна. Дэлгэрэнгүйг тайлангийн 5.1 Үржил шимт хөрс хуулалт, хадгалалт бүлгээс харна уу
2	Техникийн нөхөн сэргээлт	Хөрсний овоолго 2	га	3	Энэ оны төлөвлөгөөнд Хаягдлын 2-р овоолгын 1, 2-р доголыг налуулах техникийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөсөн байсныг бүрэн гүйцэтгэсэн. Техникийн нөхөн сэргээлтийн ажлын зургийг тайлангийн 5.2 Техникийн нөхөн сэргээлт бүлгээс харна уу

5.1 Үржил шимт хөрс хуулалт, хадгалалт

2023 оны уулын ажлын төлөвлөгөөнд нийт 53 га талбай уурхайн үйл ажиллагаанд өртөхөөр тусгагдсан. 2023 онд 09 дүгээр сарын 30-ний байдлаар нийт 77,74 га талбай уурхайн олборлолт тэлэгэнд өртөж **32,094** м3 шимт хөрсийг хуулан хадгалаад байна. Уулын ажлын өртсөн талбай, дэд бүтэц ба инженерийн ажлуудын хүрээнд хөндсөн бүх талбайн орсон билээ. 2023 онд хуулсан шимт хөрснийг 1 болон 2 овоолго 2022 онд хийсэн техникийн нөхөн сэргээлтийн талбайдуудад төвлөрүүлсэн.



Зураг 18. Дотоод хяналтын ажилтны зөвлөсний дагуу шимт хөрсийг хаягжуулсан байдал



Зураг 19. 2023 оны шимт хөрсний хуулалт болон хадгалалтыг харуулсан байдал

5.2 Техникийн нөхөн сэргээлт

Энэ оны төлөвлөгөөнд нөхөн сэргээлтийн хүрээнд Пит-2 карьерийн хаягдлын овоолгыг хэлбэржүүлж, техникийн нөхөн сэргээлтийг бүрэн гүйцэтгэсэн. Нийт 3 га талбайг 16 градус хүртэл налууулж техникийн нөхөн сэргээлт хийлээ.



Зураг 20. Техникийн нөхөн сэргээлт хийсэн байдал

6. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3-р зүйлийн 3.1.11-д "биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах" гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах, түүний ойролцоох газрын судалгааг хийх арга хэмжээг хэлнэ гэж тодорхойлсон байдаг. MV-017162 болон MV-019149 тоот тусгай зөвшөөрлийн талбайн орчимд биологийн олон янз байдлын судалгаа шинжилгээг 2018 онд мэргэжлийн байгууллага болох “Нээлхийн мандал” ХХК-аар гүйцэтгүүлсэн. 2022 онд Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хөтөлбөрийг мэргэжлийн байгууллага болон “Их монголын байгаль” ХХК хийлгэсэн ба 2023 онд тухайн төлөвлөгөөний хүрээнд эхний жилийн судалгааны ажлыг хийж хэрэгжүүлсэн.

Хүснэгт 10. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө биелэлт

№	Хэргэжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлт
1	Бэлчээрийн менежмент зохион байгуулж байгаа талбайг техноген үйл ажиллагаанаас хамгаалахын тулд / машины зам, эвдрэл, бохирдол/ “Энэ талбайд бэлчээрийн менежментийн арга хэмжээ явуулж байна” гэсэн утгатай пайз тавьж тэмдэгжүүлэх	Ноёны нуруу	6	Төсөл хариуцагч	Бэлчээрийн менежментийн цэгт “Энэ талбайд бэлчээрийн менежментийн арга хэмжээ явуулж байна” гэсэн утгатай самбарууд хийж байршуулав. Дэлгэрэнгүй мэдээллийг 6.1-р бүлгээс харна уу.
2	Зонхилох бэлчээрийн нэгж талбар бүрд ургамалжлын судалгааны мониторинг цэг байгуулна. Ойролцоогоор 6-аас багагүй цэгт	Ноёны нуруу	6	Төсөл хариуцагч	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Ноёны нуруу дагуу бэлчээрийн төлөв байдлыг судлах зорилгоор урт хугацааны мониторингийн 6 цэг байгуулж ажилласан. Дэлгэрэнгүй зурган мэдээллийг 6.2-р бүлгээс харна уу.



“Цагаан Өвөлжөө” ХХК-ийн 2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

3	Мониторинг цэгт пайз хадах ажил	Ноёны нуруу	6	Төсөл хариуцагч	Бэлчээрийн төлөв байдлыг судлах зорилгоор урт хугацааны мониторингийн 6 цэг тус бүр дээр хаягжуулалтын ажлыг хийсэн. Зурган мэдээллийг 6.3 хэсэгт оруулав.
4	Бэлчээрийн мониторинг цэг бүрд 5,6,7,8,9,10-р саруудад дараах үзүүлэлтүүдээр -Зүйлийн бүрдлийн өөрчлөлт -Бэлчээрийн ургамалжлын бүрхцийн өөрчлөлт -Бэлчээрийн ургацын өөрчлөлт	Ноёны нуруу	6	Төсөл хариуцагч	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэх хамгаалах ажлын хүрээнд Ноёны нуруу дагуу бэлчээрийн төлөв байдлыг судлах зорилгоор урт хугацааны мониторингийн 6 цэг байгуулж тухайн цэгүүдэд 5, 6, 7, 8, 9, 10 саруудад ургамлын зүйлийн бүрдлийн шинж чанарын судалгааг хийж ажиллалаа. Зүйлийн бүрдэл, ургамлын бичиглэлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг 6.4-р бүлэгт харуулсан.
5	Хөдөлгөөн мэдрэгч бүхий камераар амьтаны мониторинг судалгааг хийх	Ноёны нуруу	Тогтсон цэгүүд	Төсөл хариуцагч	Мөн 2022 онд хийлгэсэн Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд Ноёны нурууны дагуух тогтсон цэгүүдэд хөдөлгөөн мэдрэгч бүхий камераар амьтны мониторинг судалгааг хийхээр заасны дагуу 2023 онд Ноён сумын байгаль хамгаалагчаас хөдөлгөөн мэдрэгч 2 камер авч нийт 10 цэгт нэг дээр 25-30 хонгийн хугацаатай байршуулж ажиллаа. Дэлгэрэнгүй зурган мэдээллийг 6.5-р Хөдөлгөөн мэдрэгч бүхий камераар амьтаны мониторинг судалгаа хэсэгт оруулав.
6	Ган зудтай үед шаардлагатай газруудад биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Ноёны нуруу	1	Төсөл хариуцагч	2023 оны 04 дүгээр сард Биотехникийн арга хэмжээнд Ноён сумын Байгаль хамгаалагч болон Идэвхитэн байгаль хамгаалагч нар, компаний байгаль орчны мэргэжилтэн, ажилчид хамтран Ноён сумын амьтадын байрлаж нутагладаг 10 цэгт 80 боодол өвсийг байршуулан Биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Дэлгэрэнгүй мэдээллийг 6.6-ийн биотехникийн арга хэмжээ хэсэг оруулалаа.

6.1 Энэ талбайд бэлчээрийн менежментийн арга хэмжээ явуулж байна


Бэлчээрийн менежментийн цэгт “Энэ талбайд бэлчээрийн менежментийн арга хэмжээ явуулж байна” гэсэн утгатай самбарууд хийж байршуулав.



Зураг 21. Бэлчээрийн төлөв байдлын судалгааны цэгүүдийн ойролцоо самбаруудыг байршуулав

6.2 Ургамалжлын судалгааны мониторинг цэгүүд

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэх хамгаалах ажлын хүрээнд Ноёны нуруу дагуу бэлчээрийн төлөв байдлыг судлах зорилгоор урт хугацааны мониторингийн 6 цэг байгуулж ажилласан. Цэг тус бүр 10м² талбайтай.



Зураг 22. Бэлчээрийн төлөв байдлын судалгааны цэгүүдийн байршил



Зураг 23. Бэлчээрийн мониторингийн цэгүүдыг байгуулав.

6.3 Мониторинг цэгт пайз хадах ажил

Бэлчээрийн төлөв байдлыг судлах зорилгоор урт хугацааны мониторингийн 6 цэг тус бүр дээр хаягжуулалтын ажлыг хийлээ.



Зураг 24. Бэлчээрийн судалгааны цэгүүд тус бүрт пайз хадаж хаягжуулалт хийв.

6.4 Бэлчээрийн мониторинг цэг

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэх хамгаалах ажлын хүрээнд Ноёны нуруу дагуу бэлчээрийн төлөв байдлыг судлах зорилгоор урт хугацааны мониторингийн 6 цэг байгуулж тухайн цэгүүдэд 5, 6, 7,8,9,10 саруудад ургамлын зүйлийн бүрдлийн шинж чанарын судалгааг хийж ажиллалаа.

Хүснэгт 11. Судалгааны цэгүүдийн ерөнхий мэдээлэл

№	Судалгааны цэг	Ургамлын судалгааны газрын байршил /Координат/	Судалгааны хугацаа	Бэлчээрийн төлөв байдлын судалгааны цэгүүдийн гол зонхилох ургамал
1	Судалгааны цэг-1	N=43 ⁰ 10 ¹ 7.09 ^{II} E=102 ⁰ 17 ¹ 33.57 ^{II}	5, 6, 7, 8, 9, 10 сар	Монгол өвс-боролзой, холимог сөөгт,
2	Судалгааны цэг-2	N=43 ⁰ 8 ¹ 0.66 ^{II} E=102 ⁰ 20 ¹ 12.73 ^{II}	5, 6, 7, 8, 9, 10 сар	Монгол өвс-боролзойт, дэрст, бударгана
3	Судалгааны цэг-3	N=43 ⁰ 6 ¹ 34.02 ^{II} E=102 ⁰ 9 ¹ 13.70 ^{II}	5, 6, 7, 8, 9, 10 сар	Бударгана-шавагт, буйлст, харгана
4	Судалгааны цэг-4	N=43 ⁰ 1 ¹ 41.88 ^{II} E=102 ⁰ 33 ¹ 13.70 ^{II}	5, 6, 7, 8, 9, 10 сар	Баглуур-Монгол өвст, буйлс-харгана
5	Судалгааны цэг-5	N=43 ⁰ 19 ¹ 25.38 ^{II} E=102 ⁰ 33 ¹ 13.70 ^{II}	5, 6, 7, 8, 9, 10 сар	Буйлс-холимог сөөгт, дэрст
6	Судалгааны цэг-6	N=43 ⁰ 11 ¹ 3.29 ^{II} E=102 ⁰ 52 ¹ 29.99 ^{II}	5, 6, 7, 8, 9, 10 сар	Монгол өвс-боролзойт, дэрст

Ургамлын мониторинг судалгаанд даргаар аргуудыг хэрэглэлээ.

- Ургамлын зүйлийн бүрэлдэхүүн тодорхойлох
- Ургамлын бүрхэц /Халцгай, хад чулууны бүрхэц
- Ургацын өндөр тодорхойлох

Хүснэгт 12. Судалгааны цэг – 1 бэлчээрийн төлөв байдал

Бэлчээрийн хэв шинж Судалгааны цэг-1	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Ургамлын талхагдлын бүрхэц %	Халцгай газрын хэмжээ %	Хад чулууны хэмжээ %	Хагдны хэмжээ %	Ургамлын өндөр /см/
	1м ² талбайд	1м ² талбайд	10м ² талбайд					
5 дугаар сар	20	2-3	3-5	6	70	10	0	5-10
6 дугаар сар	15	1-2	4	5	75	11	0	5-10
7 дугаар сар	35	2-3	5	6	70	15	0	5-10
8 дугаар сар	40	1-2	4	7	75	10	0	5-10
9 дугаар сар	12	2-3	4	7	70	15	0	5-10
10 дугаар сар	14	1-2	3	7	75	12	0	5-10
Дундаж	24,4	2-3	3-5	6,3	73	13	0	5



Зураг 25. Судалгааны цэг-1 дээр ажиллаж буй нь



График 6. Судалгааны цэг-1 ургамлын ерөнхий тархац /10м²/

Хүснэгт 13 Судалгааны цэг –2 бэлчээрийн төлөв байдал

Бэлчээрийн хэв шинж Судалгааны цэг-2	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Ургамлын талхагдлын бүрхэц %	Халцгай газрын хэмжээ %	Хад чулууны хэмжээ %	Хагдны хэмжээ %	Ургамлын өндөр /см/
	1м ² талбайд	1м ² талбайд	10м ² талбайд					
5 дугаар сар	10	5	5	10	70	20	0	5-10
6 дугаар сар	10	5	5	10	70	20	0	5-10
7 дугаар сар	10	4	4	10	80	20	0	5-10
8 дугаар сар	10	4	4	10	80	20	0	5-10
9 дугаар сар	5	4	4	10	80	20	0	5-10
10 дугаар сар	5	4	4	10	80	20	0	5-10
Дундаж	7,5	4-5	5	10	75	20	0	5




Зураг 26. Судалгааны цэг-2 дээр ажиллаж буй нь



График 7. Судалгааны цэг-2 ургамлын ерөнхий тархац /10м²/

Хүснэгт 14. Судалгааны цэг – 3 бэлчээрийн төлөв байдал

Бэлчээрийн хэв шинж Судалгааны цэг-3	Үзүүлэлт							Ургамлын өндөр /см/
	Ургамлын бүрхэц %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Ургамлын талхагдлын бүрхэц %	Халцгай газрын хэмжээ %	Хад чулууны хэмжээ %	Хагдны хэмжээ %	
	1м ² талбайд	1м ² талбайд	10м ² талбайд					
5 дугаар сар	35	5	5	30	50	20	0	5-20
6 дугаар сар	30	4	4	30	50	20	0	5-20
7 дугаар сар	30	4	4	25	50	20	0	5-20
8 дугаар сар	30	4	4	25	50	20	0	5-20
9 дугаар сар	30	4	4	25	50	20	0	5-20
10 дугаар сар	25	4	4	25	50	20	0	5-20
Дундаж	29	4-5	4-5	27,5	50	20	0	14



Зураг 27. Судалгааны цэг-3 дээр ажиллаж буй нь



График 8. Судалгааны цэг-3 ургамлын ерөнхий тархац /10м²/

Хүснэгт 15. Судалгааны цэг – 4 бэлчээрийн төлөв байдал

Бэлчээрийн хэв шинж Судалгааны цэг-4	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Ургамлын талхагдлын бүрхэц %	Халцгай газрын хэмжээ %	Хад чулууны хэмжээ %	Хагдны хэмжээ %	Ургамлын өндөр /см/
	1м ² талбайд	1м ² талбайд	10м ² талбайд					
5 дугаар сар	25	3-4	4-6	40	40	20	0	5-20
6 дугаар сар	25	3-4	4-6	40	40	20	0	5-20
7 дугаар сар	25	3-4	4-6	40	40	20	0	5-20
8 дугаар сар	20	3-4	4-6	35	45	20	0	5-20
9 дугаар сар	20	3-4	4-6	35	45	20	0	5-20
10 дугаар сар	20	3-4	4-6	35	45	20	0	5-20
Дундаж	18	3-4	4-6	38	4.5	20	0	9,5



Зураг 28. Судалгааны цэг – 4 дээр ажиллаж буй нь



График 9. Судалгааны цэг – 4 ургамлын ерөнхий тархац /10м²/

Хүснэгт 16. Судалгааны цэг – 5 бэлчээрийн төлөв байдал

Бэлчээрийн хэв шинж Судалгааны цэг-5	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Ургамлын талхагдлын бүрхэц %	Халцгай газрын хэмжээ %	Хад чулууны хэмжээ %	Хагдны хэмжээ %	Ургамлын өндөр /см/
	1м ² талбайд	1м ² талбайд	10м ² талбайд					
5 дугаар сар	70	2	2-3	70	20	10	0	15-20
6 дугаар сар	70	2	2-3	70	20	10	0	15-20
7 дугаар сар	70	2	2-3	70	20	10	0	15-20
8 дугаар сар	70	3	2-3	70	20	10	0	15-20
9 дугаар сар	70	3	2-3	70	20	10	0	15-20
10 дугаар сар	70	2	2-3	70	20	10	0	15-20
Дундаж	70	2-3	2-3	70	20	10	0	9,5



Зураг 29. Судалгааны цэг – 5 дээр ажиллаж буй нь



График 10. Судалгааны цэг – 5 ургамлын ерөнхий тархац /10м²/

Хүснэгт 17. Судалгааны цэг – 6 бэлчээрийн төлөв байдал

Бэлчээрийн хэв шинж Судалгааны цэг-6	Үзүүлэлт							
	Ургамлын бүрхэц %	Зүйлийн бүрэлдэхүүний тоо		Ургамлын талхагдлын бүрхэц %	Халцгай газрын хэмжээ %	Хад чулууны хэмжээ %	Хагдны хэмжээ %	Ургамлын өндөр /см/
	1м ² талбайд	1м ² талбайд	10м ² талбайд					
5 дугаар сар	30	2-3	4-5	20	60	20	0	5-15
6 дугаар сар	35	2-3	4-5	20	60	20	0	5-15
7 дугаар сар	32	2-4	4-5	20	60	20	0	5-15
8 дугаар сар	28	2-3	4-5	18	60	22	0	5-15
9 дугаар сар	33	2-4	4-5	18	60	22	0	5-15
10 дугаар сар	32	2-4	4-5	15	60	25	0	5-15
Дундаж	32	2-2	4-5	17,5	60	22,5	0	8,5



Зураг 30. Судалгааны цэг – 6 дээр ажиллаж буй нь




График 11. Судалгааны цэг – 6 ургамлын ерөнхий тархац /10м²/

6.5 Хөдөлгөөн мэдрэгч бүхий камераар амьтаны мониторинг судалгааг хийх

Мөн 2022 онд хийлгэсэн Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн хүрээнд Ноёны нурууны дагуух тогтсон цэгүүдэд хөдөлгөөн мэдрэгч бүхий камераар амьтны мониторинг судалгааг хийхээр заасны дагуу 2023 онд Ноён сумын байгаль хамгаалагчаас хөдөлгөөн мэдрэгч 2 камер авч нийт 10 цэгт нэг дээр 20-30 хонгийн харилцан адилгүй хугацаатай байршуулж ажиллаа.



Зураг 31. Амьтны судалгааны автомат камер суурьлуулсан газрын байршил



Зураг 32. Камер байршуулсан байдал



Зураг 33. Хяналтын камерт бичигдсэн амьтад

Хүснэгт 18. Хяналтын камерт бичигдсэн амьтадын мэдээлэл

№	Газрын нэр	Байршил координат	Хугацаа /хоног/	Хяналтын камерт орсон амьтадын тоо	Хяналтын камерт орсон амьтад
1	Харганан	N=43 ⁰ 10 ¹ 44.72 ^{II}	30	5	Үнэг, туулай, болжмор, хярс, Бүргэд
		E=102 ⁰ 10 ¹ 35.12 ^{II}			
2	Шинэ ус	N=43 ⁰ 09 ¹ 36.15 ^{II}	30	2	Үнэг, туулай
		E=102 ⁰ 11 ¹ 31.81 ^{II}			
3	Ар задгай урд хэсэг	N=43 ⁰ 08 ¹ 47.61 ^{II}	25	0	
		E=102 ⁰ 15 ¹ 39.70 ^{II}			
4	Өвөр задгай баруун ар	N=43 ⁰ 08 ¹ 01.27 ^{II}	25	3	Үнэг, туулай
		E=102 ⁰ 15 ¹ 27.10 ^{II}			
5	Хөгшин хайрханы ар	N=43 ⁰ 07 ¹ 22.33 ^{II}	30	2	Туулай, Хярс
		E=102 ⁰ 21 ¹ 09.58 ^{II}			
6	Хөгшин хайрханы өвөр	N=43 ⁰ 06 ¹ 30.72 ^{II}	30	1	Туулай
		E=102 ⁰ 21 ¹ 11.65 ^{II}			
7	Ямаатын ар	N=43 ⁰ 08 ¹ 56.90 ^{II}	30	4	Хар сүүлт, Үнэг, Туулай хоёр удаа
		E=102 ⁰ 29 ¹ 06.51 ^{II}			
8	Улаан толгойн хяр	N=43 ⁰ 07 ¹ 35.15 ^{II}	30	2	Янгир ямаа, ишиг
		E=102 ⁰ 32 ¹ 00.34 ^{II}			
9	Шинэ усны урд хяр	N=43 ⁰ 05 ¹ 36.31 ^{II}	28	2	Туулай, Үнэг
		E=102 ⁰ 09 ¹ 27.40 ^{II}			
10	Даравгайн хярын ард	N=43 ⁰ 04 ¹ 12.98 ^{II}	28	4	Янгир, Хар сүүлт, Үнэг, Туулай
		E=102 ⁰ 09 ¹ 43.00 ^{II}			
Хяналтын камерт орсон нийт				25	

6.6 Ган зудтай үед шаардлагатай газруудад биотехникийн арга хэмжээ авах

Жил бүр цаг үеийн байдлаас шалтгаалан болзошгүй аюул, эрсдэлээс зэрлэг амьтадаа хамгаалах, хорогдол гаргахгүй байх зорилгоор нэн ховор, ховор амьтад нутагладаг өвөлжилт, хаваржилт хүндэрсэн газруудад өвс, тэжээл тавьж биотехникийн арга хэмжээ авч ажилладаг. 2023 оны 04 дүгээр сард биотехникийн арга хэмжээнд Ноён сумын Байгаль хамгаалагч болон Идэвхитэн байгаль хамгаалагч нар, компанийн байгаль орчны мэргэжилтэн, ажилчид хамтран Ноён сумын Ганзагад багийн Булаг, Булгийн дөрвөлжин, Хүйсэнгийн булаг, Харанхуй могойн ам, Янгиртын рашаан, Баруун зүүн сахилдагтай, Сайран багийн Сүвт, Бүлээний задгай, Зост булаг, Сүмбэрийн булаг, Хайлаастайн булаг зэрэг Аргал, Янгир Хар сүүлт амьтадын байрлаж нутагладаг 10 цэгт 80 боодол өвсийг байршуулан Биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Цаашид биотехникийн арга хэмжээг төлөвлөгөөний дагуу шат дараатай авч хэрэгжүүлж ажиллах юм.



Зураг 34. Биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлсэн байдал



7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй нөлөөллийн товч тодорхойлолт:

Уурхайн үйл ажиллагаанаас болж нийгэм эдийн засагт дараах хэд хэдэн төрлийн нөлөөлөл үүсч болзошгүй юм.

- **Олон нийтийн эрүүл мэндийн болон аюулгүй байдал:**
- **Малын бэлчээрийн талбай багасах**
- **Малчид болон нутгийн оршин суугчид, зарим хэрэглэгчдийн эрх ашиг хөндөгдөх**

“Цагаан Өвөлжөө” ХХК нь “Баруун Ноён Уул-1” нүүрсний төслийн хүрээнд уурхайн нөлөөллийн бүсийг тогтоож, нөлөөлөлд өртөх айл өрхүүдийн судалгааг гаргасны үндсэн дээр айлуудыг нүүлгэн шилжүүлж, нөхөн олговрыг бүрэн олгосон. Иймээс 2023 онд энэ чиглэлийн ажил төлөвлөгөдөөгүй болно.

8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн тусгай зөвшөөрөл бүхий талбайд 2012-2013 онуудад археологи палеонтологийн хайгуул судалгааны ажлыг эрдэм шинжилгээний байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлсэн бөгөөд уурхайн талбайд нийт 16 дурсгал тодорхойлогдсоныг **авран хамгаалах ажлыг** Шинжлэх Ухааны Академийн Түүх Археологийн хүрээлэнгийн эрдэмтэд судлаачидтай хамтран гүйцэтгэсэн. Төслийн талбайд 2013 оноос өнөөг хүртэл үйл ажиллагаа явуулж ирэхэд ямар нэгэн нэмэлт түүхийн дурсгал илрээгүй байна.

Хүснэгт 10. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ

№	Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Биелэлт
1	Археологи болон палеонтологийн дурсгал	Хэрэв хайгуул судалгааны явцад ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл илэрсэн тохиолдолд авран хамгаалах ажлыг Мэргэжлийн байгууллагад хандаж хэрэгжүүлнэ.	Жилийн турш	Уурхайн үйл ажиллагаа нь 2023 онд үйл ажиллагаа явуулахад ямар нэгэн нэмэлт түүхийн дурсгал илрээгүй юм.

9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Цагаан Өвөлжөө” ХХК-ийн хувьд ямар нэгэн химийн бодисийг үйл ажиллагаандаа хэрэглэхдээ гэрээт компани болох “Спешиал Майнинг Сервисес” ХХК-тай байгуулсан гэрээний үндсэн дээр тэсэлгээний үйлчилгээг хийлгэж байна. Энэ гэрээний нөхцөл нь уг ажил үйлчилгээг үзүүлэгч аж ахуйн нэгжүүд нь тусгай зөвшөөрлийнхөө хүрээнд өөрийн бараа материал (химийн бодис болон тэсрэх бодис), хүн хүчийг ашиглан ажил үйлчилгээг гүйцэтгэх бөгөөд уг ажил үйлчилгээг гүйцэтгэсний нийт төлбөрийг манай компаниас гаргуулахад оршино. Иймд уг үйлчилгээнүүдийг гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд нь химийн бодисын ашиглалт, хадгалалт, тээвэрлэлт, зайлуулалттай холбоотой холбогдох үүрэг хариуцлагыг бүрэн хүлээдэг бөгөөд бид хөндлөнгийн хяналтын хүрээнд гэрээлэгч байгууллагуудын ажлын байрны нөхцөл, тусгай зөвшөөрөл, химийн бодисын хадгалалт, тээвэрлэлт, агааржуулалтын систем, галын хор, саармагжуулагч бодис зэрэг шаардлагатай материалын бүрдэл, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, аюул, ослын үед ажиллах төлөвлөгөө, ажилчдыг сургалтанд хамруулсан байдал, хөдөлмөр хамгааллын арга хэмжээний хэрэгжилтийг шалгаж хянаж ажиллаж байна.

Хүснэгт 11. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө түүний биелэлт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ авах	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх давтамж	Биелэлт
1	Химийн бодисийн хэрэглээнд хөндлөгийн хяналт тавих	Төслийн хүрээнд	12 шалгалт	Сар бүр	Спешиал Майнинг Сервисес ХХК гэрээт байгууллагуудын химийн болон аюултай бодис хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт дээр уурхайн үйл ажиллагааны явцад тогтмол хяналт тавьж ажиллалаа. Дэлгэрэнгүйг 9.1 химийн хорт болон аюултай бодис хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтын хяналт хэсэгт оруулав.
2	Осол, аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулах	Төслийн хүрээнд	1 төлөвлөгөө	Жилд нэг удаа	2023 онд Осол, аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг Налайх дүүрэгт байрлах Уул уурхайн авран ангиар батлуулж төлөвлөгөөний дагуу ажилсан. 9.2 төлөвлөгөөний батлагдсан нүүрийг оруулав.
3	Болзошгүй аюул ослын үед нөхцөл байдлыг холбогдох байгуулагад мэдээлэх, шаардлагатай үед нэмэлт дайчилгаа зохион байгуулах	Төслийн хүрээнд	Тодорхойгүй	Шаардлагатай үед	2023 оны хувьд ямар нэгэн байдлаар гал түймэр болон олныг хамарсан бусад аюул осол бүртгэгдээгүй юм.

9.1 Химийн болон аюултай бодисын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтын хяналт

Уурхайн лабораторит ашиглах химийн бодисуудыг тухайн сард төлөвлөсөн хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр ашигладаг. Химийн бодисын хаягдалыг хамгийн бага байхаар /маш багаар/ хэрэглэдэг. Нүүрс шинжилгээний лабораторид хэрэглэдэг химийн бодисуудын нэг сарын хэрэглээний хэмжээ нь дараах байдалтай байдаг. Үүнд:

- Бензойний хүчил сард 50 грам,
- Магнийн перхлоратыг /чийг шингээгчээр/ сард 200 грам ашигладаг,
- Савангийн уусмал нь 250 грам

Шинжилгээнд ашигласан химийн бодисуудыг буцааж савлаад Монгол улсын хууль тогтоомжын дагуу устгалд оруулдаг. Химийн бодисыг ашиглах, хадгалах явцад хоорондоо нийцэхгүй бодисуудыг хамт хадгалахгүй байх. Лаборатори нь дэгдэмхий ууршигттай болон хамт хадгалах хориотой бодисууд ашигладаггүй болно. Бодис тус бүрийг хадгалалтын стандарт шаардлага хангасан кабинетэд дараах байдлаар хадгалдаг.

- Бензойны хүчлийг илчлэг тодорхойлох өрөөний хадгалах шүүгээнд дангаар
- Савангийн уусмалыг нягт тодорхойлох өрөөнд хадгалах шүүгээнд дангаар
- Магнийн перхлоратыг зориулалтийн хуванцар саванд хүхэр тодорхойлох өрөөнд дангаар тус тус хадгалдаг.





Лабораторын бодисын бохирдолтой усыг ил задгай урсгахгүй байх.

Бензойны хүчлийг нүүрсний илчлэг тодорхойлох стандарт дээжээр шинжилгээнд оруулсаны дараагаар шингэн хаягдал үүсдэг. Энэхүү шингэн хаягдлыг битүүмжлэл бүхий зориулалтын саванд цуглуулж саармагжуулалт хийдэг.

Уурхайн лабораторид шатах тослох материалаар бохирдсон хог хаягдал үүсдэггүй.

Лабораториос гарсан химийн бодисын үлдэгдэл хаягдлыг өөрсдийн химийн бодисын хаягдал хадгалах агуулахад хуримтлуулан хадгаладаг. Уурхайн талбай дээр химийн бодисын үлдэгдэл хаягдал устгах ажлыг гүйцэтгэдэггүй болно.

Лабораторын бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагааг зохих журмын дагуу явуулж байх.

Лабораторын бодисыг хэрэгцээнээс илүү хэмжээгээр өөр зориулалтаар ил задгай хэрэглэхгүй байх.

Уурхай дээрх лабораторид ашиглагдах химийн бодисуудыг тухайн сард ашиглах маш бага хэмжээгээр бага багаар хэрэглэдэг. Дараах хүснэгтээс 2023 онд хэрэглэсэн лабораторын бодисуудын хэрэглээний сар тутмын бүртгэлийг харна уу.

Хүснэгт 19. Лабораторын бодисын сар бүрийн хэрэглээний мэдээ

Лабораторийн химийн бодисуудын сар тутмын хэрэглээний бүртгэл



Урвалжийн нэр	Савангийн уусмал	Бензойны хүчил	Магнийн Перхлорат	Бүртгэл мэдээлэл хөтөлсөн огноо	Бүртгэл мэдээлэл хөтөлсөн лабораторийн ажилтан	Хянасан байгаль орчны ажилтан
Химийн томьёо	$C_{58}H_{118}O_{24}$	$C_7H_6O_2$	$Mg(ClO_4)_2$			
Зориулалт	Нүүрсний бодит нягт тодорхойлох шинжилгээнд норгогч уусмалаар хэрэглэгддэг.	Нүүрсний илчлэг тодорхойлох шинжилгээнд сертификатжсан стандарт загвар болгон хэрэглэгддэг.	Нүүрсний нийт хүхэр тодорхойлох шинжилгээнд чийг шингээгчээр ашиглагддаг.			
	Хэргэлсэн хэмжээ /кг/	Хэргэлсэн хэмжээ /кг/	Хэргэлсэн хэмжээ /кг/			
2023 он						
1 сар	0.3	0.035	0.2	31 Jan 2023	Б.Дорнодорал	Б.Ухиаа
2 сар	0.3	0.035	0.2	28 Feb 2023	Б.Дорнодорал	Б.Ухиаа
3 сар	0.3	0.035	0.2	30 Mar 2023	Б.Дорнодорал	Б.Ухиаа
4 сар	0.3	0.035	0.2	29 Apr 2023	Б.Дорнодорал	Б.Ухиаа
5 сар	0.3	0.035	0.2	25 May 2023	Б.Дорнодорал	Б.Ухиаа
6 сар	0.3	0.035	0.2	27 June 2023	Б.Дорнодорал	Б.Ухиаа
7 сар	0.3	0.035	0.2	30 July 2023	Б.Дорнодорал	Б.Ухиаа
8 сар	0.3	0.035	0.2	25 Aug 2023	Б.Дорнодорал	Б.Ухиаа
9 сар	0.3	0.035	0.2	29 Sep 2023	Б.Дорнодорал	Б.Ухиаа
10 сар						
11 сар						
12 сар						
Нийт						

“Спейшил Майнинг Сервисес” ХХК тэсэлгээнд ашиглагдах химийн бодисуудыг тухайн сард ашиглах хэмжээгээр бага багаар хэрэглэдэг. Тэсэлгээний бодисын сав баглаа боодол хаягдлыг өөрсдийн химийн бодисын хаягдал хадгалах агуулахад хуримтлуулан хадгаладаг. Уурхайн талбай дээр химийн бодисын үлдэгдэл хаягдал устгах ажлыг гүйцэтгэдэггүй бөгөөд тэсэлгээний бодис ачиж ирсэн зориулалтын техникт ачиж явж зөвшөөрөгдсөн цэгт устгалд оруулдаг юм. 2023 онд сар бүрийн байгаль орчны шалгалтыг хийсэн бөгөөд шалгалтанд ямар нэгэн зөрчил илрээгүй юм. Харин тэсэлгээний бодисын сав баглаа боодлыг ихээр хуримтлуулах хотруу ачуулахгүй удсан асуудал үүссэн хэдий ч тухай бүрд ойлгоцож хамтран ажилласан. Дахин ийм зөрчил гаргахгүй байх тал дээр хариуцсан хүмүүст нь сануулав. Мөн 2023 онд ашигласан тэсэлгээний бодисуудын сар тутмын хэрэглээний бүртгэлийг хавсралтанд хавсаргав.



Зураг 35. Тэсэлгээний бодисын агуулахын орчны харагдах байдал /Тэсэлгээний бодисын агуулахад ажлын байрны үзлэг хийх явцад орчны бохирдол хог хаягдал, эмх цэгцийн байдал харьцангуй сайн байдаг/



Хүснэгт 20. Тэсэлгээний бодисын хэрэглээний бүртгэл



"Спейшл Майнинг сервис" ХХК-ийн тэсэлгээний бодисуудын сар тутмын хэрэглээний бүртгэл

Бодисын төрөл	Задгай эмульсийн тэрэх бодис	Аммиакийн шүү	Савлагаатай Эмульсийн тэрэх бодис			
Зорнуулалт				Хэрэглээний бүртгэл хийсэн огноо	Хэрэглээний бүртгэл мэдээлэл өгсөн: "Спейшл Майнинг сервис" ХХК-ийн тэсэлгээний инженер	Хянасан: "Терра Энержи" ХХК-ийн байгаль орчны ажилтан
	Хэмжих нэгж /кг/	Хэмжих нэгж /кг/	Хэмжих нэгж /кг/			
2023 он	Хэрэглэсэн	Хэрэглэсэн	Хэрэглэсэн			
1 сар	212,732	129,481	7488	01-25	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
2 сар	440,961	168,800	4120	02-14	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
3 сар	279291	245384	—	03-25	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
4 сар	149643	320756	3596	04-25	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
5 сар	152114,9	233302,8	2616	05-28	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
6 сар	230443,6	381633	192	06-28	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
7 сар	316009,8	239205	4392	07-26	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
8 сар	316442,4	308432	9024	08-28	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
9 сар	286345,4	309281	3216	09-25	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
10 сар						
11 сар						
12 сар						
Жилийн нийт хэрэглээ						



Хүснэгт 21. Тэсэлгээний бодис хүлээн авсан бүртгэл



"Спейшл Майнинг сервис" ХХК-ийн тэсэлгээний бодис хүлээн авсан сар тутмын мэдээ

2023.

Бодисын төрөл	Задгай эмульсийн гэрэх бодис	Аммиакын шүү	Савлагаатай Эмульсийн тэсрэх бодис	Хяналт хийсэн огноо	Мэдээлэл өгсөн: "Спейшл Майнинг сервис" ХХК-ийн тэсэлгээний нягткер	Хянасан: "Терра Энержи" ХХК-ийн байгаль орчны ажилтан
Зориулалт						
	Хэмжих нэгж /кг/	Хэмжих нэгж /кг/	Хэмжих нэгж /кг/			
	Хүлээн авсан	Хүлээн авсан	Хүлээн авсан			
2023 он	Хүлээн авсан	Хүлээн авсан	Хүлээн авсан			
1 сар	190,000	182,600	10,000	01.02	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
2 сар	30,4000	149,000	—	02.02	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
3 сар	311000	256850	10000	03.05	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
4 сар	214,242,2	273,000	8596	04.04	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
5 сар	217319	179300	—	05.03	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
6 сар	236000	330000	—	06.02	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
7 сар	350,000	234600	10008	07.04	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
8 сар	452060	183844	9024	08.05	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
9 сар	382000	391000	14592	09.03	<i>[Signature]</i>	<i>[Signature]</i>
10 сар						
11 сар						
12 сар						
Жилийн нийт хэрэглээ						

9.2 Аюул ослын төлөвлөгөө

Уурхайн үйл ажиллагааны хүрээнд Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг Онцгой Байдлын Ерөнхий Газрын харьяа Налайхын Уул уурхайн аврах ангиар батлуулсан. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Өмнөговь аймгийн ОБГ-аар батлуулж ажиллалаа.



Зураг 36. 2023 оны Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний батлагдсан нүүрнүүд



10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн үйл ажиллагааны дүнд үүсэж буй хог хаягдлын байгаль орчинд ээлтэй, ангилах, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах зорилготойгоор ажиллаж байна.

Хүснэгт 22. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Ангилал	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Хэрэгжүүлэх хугацаа	Биелэлт
1	Ахуйн	Уурхайн үйл ажиллагаанаас гарч байгаа энгийн хог хаягдлын гэрээг холбогдох байгууллагатай хийх Гэрээний дагуу зохицуулах	Төслийн талбай	Тонн	Жилийн турш	Ахуйгаас гарч буй хог хаягдлын “Говийн ноён өгөөж” ХХК гэрээ байгуулан хог хаягдлын журмын дагуу зохицуулж байна. 10.1 хэсгээс дэлгэрүүлэн оруулав.
2	Аюултай	Ашигласан тос, тосолгооны материалыг дахинболовсруулах зорилгоор холбогдох компанид хүлээлгэн өгч, баримтыг бүрдүүлэх	Хаягдал тос цуглуулах цэг	Тонн	Жилийн турш	Ашигласан техникийн тос буюу аюултай хаягдлыг “Алтан Оршихуй” ХХК-д нийлүүлэх тухай гэрээг компани хооронд байгуулан хаягдлыг шилжүүлэхэд бэлэн болоод байна. Тус компани 20, 10 тонноор гэрээний дагуу 2 удаа хүлээлгэн өгөөд байна. Цаашид тогтмол тус компанид хүлээлгэн өгөхөөр гэрээний дагуу тогтмол хүлээлгэн өгөх юм. 10.2 хэсэгт дэлгэрүүлэн оруулав.
3	Аюултай	Аюултай хог хаягдлын үүсгэгчийн бүртгэлийн дугаарыг орон нутгийн байгаль орчны албанд хандаж авах	Хаягдал тос цуглуулах цэг	Тонн	8-р сард	Аймгийн байгаль орчны албанд хандаж аюултай хог хаягдал үүсгэгчийн Ү-дугаарын авсан юм. 10.3 хэсгээс дэлгэрүүлэн оруулав.
4	Ахуйн үйлдвэр	Хог хаягдалын бүртгэл хөтлөх	Төслийн талбай	Тонн	Жилийн турш	Хог хаягдлыг сар бүр хөтлөн явуулдаг ба гэрээний дагуу Говийн ноён өгөөж ХХК хүлээлгэн өгч байна. Хуванцар савыг 2023 оноос уурхайд хуримтлуулж ажиллаж байна. 10.4 бүлэгт дэлгэрүүлэн оруулав.



“Цагаан Өвөлжөө” ХХК-ийн 2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

5	Ахуйн	Гэрээт байгууллагуудын хог хаягдал, хяналт тавьж, ажлын байрны үзлэг хийх	Төслийн талбай	Тонн	Жилийн турш	2023 оны хувьд уурхайн үйл ажиллагааны явцад 14 хоногт нэг удаа бүх гэрээт байгууллагуудын ажлын байрны үзлэгийг тогтмол хийж ажилласан. Ажлын байрны үзлэгээр илэрсэн зөрчлийг тухай бүрд хариу арга хэмжээ авч ажилласан. 10.5 хэсэгт дэлгэрүүлэн оруулав.
6.		Хуванцар савыг ангилан ялгах сав болон цэг байгуулах		Ширхэг		Хуванцар сав ангилах, савыг цуглуулахаар нийт 15 цэгт сав байршуулсан бөгөөд бүх цэгүүдийн хогийн нэгтгэх 4X8 харьцаатай хуванцар сав цуглуулах хашааг хийсэн юм. Цаашид ирэх жилийн төлөвлөгөөнд хуванцар сав багцлагч авч орон нутгийн 2-догч түүхий эд авах цэгт тушааж ажиллахаар төлөвлөөд байна. Дэлгэрэнгүй мэдээллийг 10.6 хэсгээс харна уу.

10.1 Уурхайн үйл ажиллагаанаас гарч байгаа энгийн хог хаягдлын гэрээг холбогдох байгууллагатай хийх гэрээний дагуу зохицуулах

Уурхайн талбайд үүсч буй хаягдлыг аль болох бууруулах, багасгах чиглэл барин ажиллаж байгаа бөгөөд үндсэн суурь нь хаягдлын ангилан ялгалт бөгөөд компанийн хувьд Монгол улсын хууль журамд нийцсэн дотоод журмын хэрэгжилтийг хангах замаар хаягдлын ангилан ялгалтыг хэрэгжүүлдэг. 2023 онд дахин ашиглалтыг дэмжих зорилгоор поошиг, дугуйг орон нутгийн иргэдийн хүсэлтийн дагуу хүлээлгэн өгсөн. Эмнэлгийн хог хаягдлыг Ноён сумын эмнэлэг-тэй хийсэн хамтран ажиллах гэрээний дагуу хүлээлгэн өгч устгуулж байна. Засвар үйлчилгээнээс гарах мод, модон хаягдлыг уурхайн ажилчдын хотхоны хажууд хурааж хүйтний улиралд түлшинд хэрэглэж байна. Ахуйгаас гарч буй дахин ашиглах боломжгүй хог хаягдлын “Товийн ноён өгөөж” ХХК-тай гэрээ байгуулан 2 хоногт нэг удаа хог хаягдлын уурхайд ирж авах замаар зохицуулж байна.



Зураг 37. Малчин Золзаяагийн 2 машин ашиглагдсан дугуйг хүлээлгэн өгөв



БАТЛАВ:
“Говийн Ноён Өгөөж” ХХК-ийн
Захирагч: /Ц.Баатар-Эрдэнэ/



БАТЛАВ:
“Цагаан Өвөлжөө” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал: /Матгю Кауфорд/

ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭН УСТГАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2021 оны 11 дугаар сарын 28 өдөр

№ TE-CNT-0709 Өмнөговь аймаг Ноён сум

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Хог хаягдлын тухай хуулийн 10-р зүйлийн 10.2.3 - 10.2.5 дугаар зүйлүүдийг тус тус үндэслэн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж болон хог хаягдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгжийн хооронд зөвхөн энгийн хог хаягдлыг ачих, тээвэрлэх, зориулалтын цэгт хүргэх үйлчилгээг үзүүлэх зорилгоор байгуулав.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ТАЛУУД

Энэхүү Гэрээг нэг талаас Монгол улс, Өмнөговь аймаг, 1-р баг, Сайран, Залаа хороололд бүртгэлтэй “Говийн Ноён Өгөөж” ХХК (цаашид “Гэрээлэгч” гэнэ), нөгөө талаас Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Нарны зам - 91, Санроуд Барилга, 6-р давхарт байрлах “Цагаан Өвөлжөө” ХХК болон “Энхтунх Орчлон” ХХК (цаашид Үйлчлүүлэгч гэнэ) нарын хооронд байгуулав.

ГУРАВ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

1. Үйлчилгээ үзүүлэх тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж уурхайн талбай руу нэвтрэх зөвшөөрлийг олгоно.
2. Жолоочийг согтууруулах зүйл болон халдварт КОВИД-19 дархлаажуулалтын бүрэн тунг хийлгэсэн эсэхийг шалгасны үндсэн дээр уурхайн бүсэд нэвтрүүлнэ. Шаардлагатай бол КОВИД-19 шинжилгээний хариу нэхэх эрхтэй бөгөөд энэ тохиолдолд 3 хоногийн өмнө мэдэгдэнэ.

Зураг 38. Дахин ашиглах боломжгүй хог хаягдал цуглуулах, тээвэрлэх усгах үйлчилгээ үзүүлэх гэрээ



Зураг 39. Долоо хоног бүрийн 3 дах өдөр нийтийн цэвэрлэгээ хийж ажиллаж байна.

10.2 Ашигласан тос, тосолгооны материалыг дахин боловсруулах зорилгоор холбогдох компанид хүлээлгэн өгч, баримтыг бүрдүүлэх

“Алтан оршихуй” ХХК-ийн “Ахуй Мандал” дахиавар боловсруулах үйлдвэртэй уурхайн талбайгаас гарах хаягдал тосыг нийлүүлэх гэрээг 2023 оны 4 сард 2 жилийн хугацаатай байгуулсан. Тус үйлдвэр Улаанбаатар хотын Багахангай дүүрэгт байрлах үйлдвэр нь 2011 онд ашиглалтад орсон бөгөөд өдөрт 10-12 тонн хаягдал тос дахин боловсруулж Евро-4 стандартыг хангасан 7-8 тонн дизель түлш үйлдвэрлэх хүчин чадалтай. Тус компанид 2023 онд хаягдал тосыг 20 тн, 10 тн-оор гээд 2 удаа хүлээлгэн өгсөн билээ. Хаягдал тос хүлээлгэн өгсөн баримтыг тайланд хавсаргав.



Зураг 41. 2023 оны 6 дугаар сард хаягдал тос хүлээлгэн өгч буй байдал



Зураг 41. 2023 оны 10 дугаар сард хаягдал тос хүлээлгэн өгч буй байдал



ТЕХНИКИЙН ХАЯГДАЛ ТОС, ТОСОЛГООНЫ ШИНГЭНИЙ ХАЯГДАЛЫГ
ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ГЭРЭЭ
№ TSU-CNT-0885

2023 оны 04-р сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү Техникийн хаягдал тос, тосолгооны шингэн хаягдалыг хүлээлгэн өгөх гэрээ /цаашид “Гэрээ” гэх/-г нэг талаас Өмнөговь аймгийн Ноён суманд байрлах 5352827 тоот регистрийн дугаар бүхий “Цагаан Өвөлжөө” ХХК /цаашид “Үүсгэгч” гэх/-ийг төлөөлж Байгаль орчны ахлах ажилтан албан тушаалтай Ж.Банзрагч нөгөө талаас Улаанбаатар хот Багахангай дүүрэг 1-р хороо химийн гудамжинд байрлах 5537266 регистрийн дугаартай “Алтан Оршихуй Групп” ХХК /цаашид “Боловсруулагч” гэх/-ийг төлөөлж Хангамж, борлуулалтын менежер албан тушаалтай Д.Ариунмөрөн нар /хамтад нь “Талууд” гэх/ Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, байгаль орчны нөлөөлөх байдалын багц хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн дараах нөхцөлтэйгээр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь Үүсгэгч нь өөрийн үйлдвэр, уурхайгаас гарах техникийн ашигласан тос, тосол, гидрийн шингэн болон бусад тосолгооны шингэний хаягдал /цаашид “Хаягдал тос” гэх/-ийг холбогдох дүрэм, журмын дагуу цуглуулах, хадгалан Үүсгэгчээс Боловсруулагчид шилжүүлэх, Боловсруулагч нь тээвэрлэх, хүлээн авах, устгахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Хаягдал тос нь хог хаягдлын ангилалын төрлөөр аюултай хог хаягдлын А зэрэглэлд \БОАЖЯСайдын А/349 тоот кодчилсон жагсаалтанд\ багтсан байгаль орчинд хор аюулын чанартай шингэн хог хаягдал юм.
- 1.3. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхдээ байгаль орчны бохирдол гаргахгүй, талын аюулгүй байдлыг бүрэн сахиж, техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг бүрэн хангасан нөхцөлд үйл ажиллагаа явуулах шаардлагатай.
